



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 184


Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 24/3 тоот тогтоолоор батлагдсан “Улаанбаатар орон сууц сангаас төрийн албан хаагчдад орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэхэд баримтлах журам”, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 71 тоот тогтоолоор батлагдсан “Орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг авах төрийн албан хаагчийг сонгон шалгаруулахад баримтлах нийтлэг журам”, тус газрын Дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Орон сууцны сангаас урьдчилгаа төлбөрийн дэмжлэг авах, сонгон шалгаруулахад баримтлах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн /Б.Жаргалан/-д даалгасугай

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2015 оны 09 сарын 08-ны  
өдрийн 107 тоот тушаалын хавсралт

**ОРОН СУУЦНЫ САНГААС УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН  
ДЭМЖЛЭГ АВАХАД БАРИМТЛАХ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү журмаар “Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 17/17 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн орон сууцны хөтөлбөр”-т нийслэлийн Аялал жуулчлалын газрын албан хаагчдыг хамруулах, орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулна.
- 1.2. Хөтөлбөрт "Улаанбаатар-орон сууц сангаас төрийн албан хаагчдад орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэхэд баримтлах журам"-ын шаардлага хангасан албан хаагчид хамрагдана.
- 1.3. Нийслэлийн Аялал жуулчлалын газар /цаашид “Газар” гэх/-ын албан хаагчид орон сууц худалдан авах урьдчилгаа төлбөрт дэмжлэг үзүүлэхдээ "Улаанбаатар-орон сууц сангаас төрийн албан хаагчдад орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэхэд баримтлах журам", "Орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг авах төрийн албан хаагчийг сонгон шалгаруулахад баримтлах нийтлэг журам" болон энэхүү журмыг баримтална.

**ХОЁР. ОРОН СУУЦНЫ ДЭМЖЛЭГТ ХАМРАГДАХ  
АЛБАН ХААГЧДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 2.1. Нийслэлийн харъяа төрийн байгууллагад 3-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх.
- 2.2. Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод заасан зорилго, чиг үүргийн хэрэгжилтийг сайн хангаж, 80-аас дээш хувиар тогтмол үнэлэгээтэй байх.
- 2.3. Тухайн ажлын байранд цаашид тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах.
- 2.4. Ёс зүй, хувийн ашиг сонирхлын зөрчилгүй байх.
- 2.5. Худалдан авах орон сууцныхаа зээлийн урьдчилгаа төлбөрийн 50-иас доошгүй хувийг бүрэн төлж барагдуулах чадвартай байх, урьдчилгаа төлбөр дутагдалтай боловч харилцагч банк, санхүүгийн байгууллагын зээл олгох бусад шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх.
- 2.6. Ипотекийн зээлд хамрагдах нөхцөл, шалгуурыг хангасан байх.

**ГУРАВ. ОРОН СУУЦНЫ ДЭМЖЛЭГТ ХАМРАГДАХ ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХ**

- 3.1. Орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэгт хамрагдах хүсэлтийг хүлээн авах, хэлэлцэх хугацааг тухай бүр Даргын зөвлөлийн хурал /цаашид “Хурал” гэх/-аас тогтооно.
- 3.2. Дэмжлэгт хамрагдах хүсэлт, холбогдох материалыг хүсэлт гаргагч нь хурлын нарийн бичгийн даргад заасан хугацаанд багтаан өгнө.

- 3.3. Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн байгууллагын ажилтны орон сууцны эрэлт нийлүүлэлтийн талаарх судалгааг гаргаж, орон сууцны зээлд хамрагдах хүсэлтийг хамт олны хуралд танилцуулах, хурлаар хэлэлцэн баталгаажуулна.
- 3.4. Хурлаар тухайн жилд байгууллагад олгосон квотын дагуу албан хаагчдын ажилласан жил, ажлын үр дүн, мэргэжлийн ур чадвар бусад зүйлийг харгалзан нэр дэвшүүлнэ.
- 3.5. Хурал нь орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэгт хамруулах албан хаагчийг шалгаруулахдаа хүсэлт гаргасан албан хаагчдын бүрийн материалыг хэлэлцах ба хурлаас шийдвэр гаргахдаа дараах нөхцөл, байдлыг харгалзан үзнэ. Үүнд: Ажлын үр дүн, ажилласан жил, амьдралын нөхцөл, ажлын болон хөдөлмөрийн амжилт, эрүүл мэндийн болон нийгмийн байдал /хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон, олон хүүхэдтэй зэрэг/, хамт олны санал.
- 3.6. Тухайн жилийн дэмжлэгт хамрагдаагүй албан хаагчид дараагийн жилд дахин хүсэлт гаргаж болно.
- 3.7. Хурлаас гарсан шийдвэрийг үндэслэн дэмжлэгт хамрагдах албан хаагчдын ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг "Улаанбаатар-Орон сууц сан"-д баталгаажуулж хүргүүлнэ.
- 3.8. Газар нь аливаа байдлаар банкыг төлөөлөхгүй, банкны өмнөөс шийдвэр гаргахгүй, амлалт өгөхгүй байх.

#### **ДӨРӨВ. БУСАД**

- 4.1. Энэхүү журмыг нийт албан хаагчаар хэлэлцүүлэн Аялал жуулчлалын газрын даргыг тушаалаар батлан мөрдүүлэх ба нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах асуудлыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 4.2. 2.1, 2.4-т заасан шалгуурыг "Орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг авах төрийн албан хаагчийг сонгон шалгаруулахад баримтлах нийтлэг журам"-н 2 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр тодорхойлно.
- 4.3. Энэхүү журмаар зохицуулагдаагүй харилцааг "Улаанбаатар-орон сууц сангаас төрийн албан хаагчдад орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэхэд баримтлах журам" болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.